

**СҮХБААТАР ДҮҮРГИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ АЛБАНЫ
2024 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН
БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАЛТЫН ТУХАЙ ТАЙЛАН**

2025.02.10

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Сүхбаатар дүүргийн Засаг даргын дэргэдэх Худалдан авах ажиллагааны алба нь дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 02/15 дугаар тогтоолоор батлагдсан дүүргийн Төсвийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөгөөг хүлээн авч боловсруулан төрийн худалдан авах ажиллагааны цахим системд мэдээлэн ажиллалаа.

1.1 Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны 1 дүгээр сарын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн талаар: /санхүүжилтийн эх үүсвэр тус бүрээр/

а. Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих бараа, ажил, үйлчилгээ худалдан авалт:

Дүүргийн ИТХ-аас дүүргийн төсвийн хөрөнгөөр нийт 83,643.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий хөрөнгө оруулалтын 113 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлагдсан.

Худалдан авах ажиллагааны хэрэгжилт дараах байдалтай байна. Үүнд:

№	Худалдан авах ажиллагааны зохион байгуулалт	Төсөвт өртөг (сая. Төг)	Төсөл арга хэмжээний тоо
1	Тендерийн баримт бичиг боловсруулж байгаа	6135.7	31
2	Захиалга ирээгүй болон үнэлгээний хороо байгуулагдаагүй	77507.5	82
ДҮН		83643.2	113

б. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих бараа, ажил, үйлчилгээ худалдан авалт:

Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжих 1798.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 3 төсөл арга хэмжээ батлагдсан.

Худалдан авах ажиллагааны хэрэгжилт дараах байдалтай байна. Үүнд:

№	Худалдан авах ажиллагааны зохион байгуулалт	Төсөвт өртөг (сая. Төг)	Төсөл арга хэмжээний тоо
1	Захиалга ирээгүй болон үнэлгээний хороо байгуулагдаагүй	1798.5	3
ДҮН		1798.5	3

в. Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих /худалдан авах ажиллагааны эрх шилжин ирсэн/ бараа, ажил, үйлчилгээ худалдан авалт:

2025 оны 1 дүгээр сарын байдлаар улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих буюу худалдан авах ажиллагааны эрх шилжиж ирсэн төсөл арга хэмжээ байхгүй болно.

г. Дүүргийн төсвийн бусад эх үүсвэрээр хэрэгжих бараа, ажил, үйлчилгээ худалдан авалт:
Дүүргийн Засаг даргын захирамжаар дүүргийн төсвийн бусад эх үүсвэрийн хөрөнгөөр санхүүжих тухайн цаг үеийн шинж чанартай худалдан авалтыг зохион байгуулахаар 2025

оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 18035.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 23 төсөл арга хэмжээ тусгагдсан.

№	Худалдан авах ажиллагааны зохион байгуулалт	Төсөвт өртөг (сая. Төг)	Төсөл арга хэмжээний тоо
1	Захиалга ирээгүй болон үнэлгээний хороо байгуулагдаагүй	18035.3	23
ДҮН		18035.3	23

1.2 Тендер шалгаруулалтын үнэлгээг тендерийн хүчинтэй байх хугацаанд хийсэн эсэх талаар:

2025 оны 1 дүгээр сарын байдлаар захиалагчаас ирүүлсэн ажлын даалгаварын хүрээнд тендерийн баримт бичиг боловсруулах ажил хийгдэж байна.

1.3 Худалдан авах ажиллагааны явцад гарсан зөрчил, түүнийг хэрхэн залруулсан талаар:

2025 оны 1 дүгээр сарын байдлаар худалдан авах ажиллагааны талаар зөрчил гараагүй болно.

1.4 Худалдан авах ажиллагааны талаар гарсан гомдол, түүнийг шийдвэрлэсэн байдлын талаар:

2025 оны 1 дүгээр сарын байдлаар худалдан авах ажиллагааны талаар гомдол гараагүй болно.

1.5 Ногоон худалдан авалт болон дотоодын бараа худалдан авсан талаар:

2025 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд 1750.0 сая төгрөгийн 4 төсөл арга хэмжээний ногоон худалдан авалт зохион байгуулахаар тусгагдсан.

ХОЁР. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЦАХИМ СИСТЕМИЙГ АШИГЛАСАН ТАЛААР

2.1 Худалдан авах ажиллагааны цахим системээр зарласан тендер шалгаруулалтын тоо, хувь болон системийн талаар:

2025 оны 1 дүгээр сарын байдлаар захиалагчаас ирүүлсэн ажлын даалгаварын хүрээнд тендерийн баримт бичиг боловсруулах ажил хийгдэж байна.

2.2 Ерөнхий гэрээ байгуулах журмын дагуу цахим дэлгүүрийн ашиглалт болон утхайн жилд худалдан авсан бараа, үйлчилгээний тоо, мөнгөн дүн, гэрээний хэрэгжилтийн талаар:

2025 оны 1 дүгээр сарын байдлаар ерөнхий гэрээний журмын дагуу хийсэн худалдан аварт байхгүй болно.

ГУРАВ. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ДҮГНЭЛТ:

3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч тухайн жилийн худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн үр дүнгийн талаарх дүгнэлт:

ДИТХ-ын тогтоолоор 2025 онд хэрэгжүүлэхээр нийт 103,476.98 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 139 төсөл арга хэмжээ батлагдаж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан төрийн худалдан авах ажиллагааны цахим системд нийтэлсэн ба худалдан авах ажиллагааны бэлтгэл ажлыг хангаж ажиллалаа.

МЭДЭЭЛЛИЙН НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД БАЙДАЛ:

Дүүргийн Засаг даргын баталсан Худалдан авах ажиллагааны зохион байгуулалтын 2025 оны жилийн төлөвлөгөөг www.tender.gov.mn, дүүргийн ЗДТГ-ын www.sbd.gov.mn, www.shilendans.gov.mn, www.report.ub.procurement.mn цахим хуудсуудад, мөн дүүргийн худалдан авах ажиллагааны албаны мэдээллийн самбарт байршуулан олон нийтэд нээлттэй мэдээллээ.